

## ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2009 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

Геологийн салбарын инженерүүдэд  
мэргэшлийн зэрэг олгох зөвлөл байгуулах тухай

Инженер-техникийн ажилтнуудын мэргэшлийг тасралтгүй дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Геологийн салбарын инженерүүдэд Мэргэшсэн ба зөвлөх инженерийн зэрэг олгох сургалтыг Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Геологи, Газрын Тосны Сургуулийг түшиглэн зохион байгуулсугай.
2. “Геологийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох Зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Геологийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн ажиллах дүрэм”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Геологийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. “Салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох шалгалт авах журам”, “Зөвлөх инженерийн зэрэг горилох төгсөлтийн ажлын хураангуй бичих заавар” зэргийг боловсруулан баталж, шалгалт авах комиссыг салбарын эрдэмтэд, тэргүүлэх мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр тухай бүр байгуулж ажиллуулахыг Зөвлөлийн дарга (Д.Хүрэлбаатар), орлогч (Д.Чулуун) нарт даалгасугай.

САЙД

Д.ЗОРИГТ

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын  
2009 оны 08 дугаар сарын 18–ны өдрийн  
227 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**“ГЕОЛОГИЙН САЛБАРЫН ИНЖЕНЕРҮҮДЭД  
МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЗӨВЛӨЛ” -ийн бүрэлдэхүүн**

- Зөвлөлийн дарга: Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга,
- Орлогч дарга: ШУТИС-ийн Геологи, газрын тосны сургуулийн захирал\*,
- Гишүүд:
- ЭБЭХЯ-ны Геологийн бодлогын газрын дарга,
  - ЭБЭХЯ-ны ГБГ–ын орлогч дарга/ахлах мэргэжилтэн,
  - Ашигт малтмалын газрын Геологийн хэлтсийн дарга,
  - Газрын тосны газрын геологийн судалгаа, нөөц хариуцсан хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн,
  - ШУТИС-ийн ГГТС-ийн Ашигт малтмалын салбарын профессор\*,
  - ШУТИС-ийн ГГТС-ийн Геологийн салбарын профессор\*,
  - ШУТИС-ийн ГГТС-ийн Газрын тос, өрөмдлөгийн салбарын профессор\*,
  - МУИС-ийн ГГФ-ийн Геологийн салбарын профессор\*,
  - МҮГХ–ны удирдах зөвлөлийн гишүүн\*,
  - МГХ–ны удирдах зөвлөлийн гишүүн\*,
- Зөвлөлийн нарийн бичгийн дарга: ШУТИС-ийн ГГТС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга/эрдмийн зөвлөлийн гишүүн\*,

\* тохиролцсоноор

## ГЕОЛОГИЙН САЛБАРЫН ИНЖЕНЕРҮҮДЭД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ДҮРЭМ

### *Нэг. Нийтлэг үндэслэл*

- 1.1. “Геологийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох зөвлөл”-ийн (цаашид **Зөвлөл** гэнэ) үйл ажиллагааг энэ дүрмээр зохицуулна.
- 1.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ЭБЭХ–ний сайдын тушаалаар батлах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн нь дарга, сургалт хариуцсан орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Зөвлөл нь орон тооны бус байна.
- 1.3. Зөвлөлийн зорилго нь Геологийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох сургалтын ажлыг удирдан зохион байгуулах, зэрэг олгох тогтолцоог цаашид тасралтгүй сайжруулж боловсронгуй болгоход оршино.
- 1.4. Зөвлөл нь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Геологи, газрын тосны сургууль дээр төвлөрч ажиллана.
- 1.5. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг мэргэшлийн зэрэг горилогчдын төлбөр болон бусад орлогоос гаргана.

### *Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагаа*

- 2.1. Зөвлөл нь геологийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан дадлага туршлага бүхий инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох ажлыг холбогдох журмын дагуу удирдан зохион байгуулах, үүнтэй холбогдсон асуудлуудыг судлах, хэлэлцэж шийдвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 2.2. Зөвлөл нь мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгаруулалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зэрэгтэй инженерүүдэд тодорхойлолт, мэргэшлийн хүрээ, эрхлэх ажил үйлчилгээний чиглэл зэргийг хэлэлцэж батална.
- 2.3. Зөвлөл нь мэргэшлийн зэрэг горилогчдыг шалгаруулахтай холбогдсон журмуудыг боловсруулан батлуулж мөрдөнө.
- 2.4. Зөвлөлийн асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах ажиллагаа нь зөвлөлийн гишүүдийн хуралдаанаар дамжин хэрэгжинэ.
- 2.5. Зөвлөлийн хурал нь нийт гишүүдийн 80 аас доошгүй хувийн ирцтэй байж ирцийн хувьд хүчин төгөлдөр болно.
- 2.6. Зөвлөлийн шийдвэр нь нууц санал хураалтын үр дүнгээр гарах бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн 75 аас дээш хувийн санал авсан тохиолдолд хүчинтэй болно.

- 2.7 Зөвлөлийн хурлаас гаргасан тэмдэглэлийг үндэслэн Зөвлөлийн шийдвэрийг Зөвлөлийн даргын тушаалаар баталгаажуулна.

### ***Гурав. Зөвлөлийн эрх***

- 3.1. Зөвлөл нь шалгалт авах ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангахын тулд мэргэшлийн шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэрийг үндэслэн Зөвлөлийн орлогч дарга (ШУТИС-ийн Геологи, газрын тосны сургуулийн захирал)-ын тушаалаар томилно. Шалгалтын комиссын гишүүдэд тухайн салбарын тэргүүлэх мэргэжилтэн, эрдэмтэд, их сургуулийн профессор багш нараас сонгоно.
- 3.2. Зөвлөл нь шаардлагатай тохиолдолд шалгалтын комиссын шийдвэрийг хүчингүй болгох, комиссыг дахин шинээр томилох эрхтэй.
- 3.3. Зөвлөл нь мэргэшлийн зэрэг горилогчдын сургалтын төлбөрийн хэмжээг тогтооно.
- 3.4. Зөвлөл нь инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох, хугацааг сунгах, цуцлах эрхтэй.

### ***Дөрөв. Зөвлөлийн үүрэг, хариуцлага***

- 4.1. Зөвлөл нь шалгаруулалтын бүхий л үе шатыг хөндлөнгийн нөлөөгүй байх ерөнхий зарчмыг баримтлан зохион байгуулж хяналт тавина.
- 4.2. Зөвлөлийн гишүүд нь үйл ажиллагаандаа холбогдох дүрэм журмыг чанд баримтлан ажиллана.
- 4.3. Зөвлөл нь шалгаруулалт явуулж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор зэрэг, эрх олгосон, сунгасан болон цуцалсан шийдвэрийг гаргаж шалгаруулалтад оролцогчдод мэдэгдэнэ.
- 4.4. Зөвлөл нь мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон асуудлаар өргөдөл, гомдол санал, хүсэлтийг хүлээн авч барагдуулна.
- 4.5. Зөвлөл нь сургалтын чанар, багш нарын талаар төгсөгчдөөс үнэлгээ авч үйл ажиллагаандаа дүгнэлт хийж ажиллана.
- 4.6. Зөвлөл нь энэхүү журамд заагдаагүй нөхцөл байдлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актыг баримтлан шийдвэрлэнэ.

### ***Тав. Зөвлөлийн үйл ажиллагаанд тавих хяналт***

- 5.1. Зөвлөл нь үйл ажиллагаагаа жилд нэг удаа Сайдын зөвлөлд тайлагнана.
- 5.2. Зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод болон бусад мэргэжлийн зохих байгууллагууд хяналт тавина.

## ГЕОЛОГИЙН САЛБАРЫН ИНЖЕНЕРҮҮДЭД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

**1.1** Монгол Улсын геологийн салбарын дээд боловсролтой инженерүүдэд (геологи, геофизик, өрөмдлөг, гидрогеологи, газрын тосны хайгуулын) мэргэшлийн зэрэг олгох, түүнийг төрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулж, хяналт тавихтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

**1.2** Геологийн салбарын инженерүүдэд мэдлэг, мэргэшлийн ур чадвар, түвшин, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, бүтээл, туршлагыг үнэлэх, тэдний ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Мэргэшлийн зэрэг нь цаашид мэргэжлээрээ аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх олгох үндэслэл болно.

**1.3** Геологийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох, сунгах, цуцлах ажиллагааг удирдах, түүнд хяналт тавих ажлыг Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Мэргэжлийн холбоодын (Монголын үйлдвэрлэлийн геологчдын холбоо, Монголын геологчдын холбоо, Монголын геофизикчдийн холбоо, Монголын өрөмдлөгийн холбоо) хамтарсан "Геологийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох" зөвлөл /цаашид **Зөвлөл** гэнэ/ эрхэлнэ.

**1.4** Геологийн салбарын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд, захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд, иргэд тухайн зэрэглэлтэй мэргэжилтний гаргасан алдааг зөвлөлд тухай бүр мэдээлж байна. Энэ нь мэргэшлийн зэргийг олгох, сунгах, цуцлах үндэслэл болно.

**1.5** Дээд боловсролтой геологийн салбарын инженерийн зэрэг нь **Мэргэшсэн** ба **Зөвлөх** гэсэн шатлалтай байна.

**1.6** Мэргэжил дээшлүүлэх, зэрэг олгох, сунгах ажиллагаатай холбогдсон Зөвлөлийн шийдвэрийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Геологи, газрын тосны сургуульд түшиглэсэн төв хэрэгжүүлнэ.

**1.7** Зэрэгтэй инженерийн шалгаруулалтын материал, мэдээлэл, бусад холбогдох баримт бичгийг дээрх сургууль дээр хадгална.

## **Хоёр. Зэрэг горилогчид тавих шаардлага**

### **2.1** Горилогч дараах болзлыг хангасан байна. Үүнд:

- Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль төгсөж дээд (бакалавр, магистр, доктор) боловсрол эзэмшсэн байна.
- **Мэргэшсэн** зэрэг горилогч нь бакалаврын боловсрол эзэмшсэнээс хойш сүүлийн 8, магистрын зэрэг хамгаалсанаас хойш 5-аас доошгүй жил тасралтгүй мэргэжлээрээ ажилласан, үүнээс 3-аас доошгүй жил үйлдвэрлэл дээр ажилласан, мэргэжлийн чиглэлээр ерөнхий мэдлэгийн шалгалт амжилттай (>80 оноо) өгсөн байна.
- **Зөвлөх** зэрэг горилогчид нь мэргэшсэн зэрэг заавал авсан байх бөгөөд мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс мэргэшсэн зэрэг авсанаас хойш 4 жил үр бүтээлтэй ажилласан байна. Түүнчлэн мэргэжлийн чиглэлээр ерөнхий мэдлэгийн шалгалт амжилттай (>80 оноо) өгсөн байна.
- Горилогчийн бүтээл нь мэргэжил дээшлүүлэх талаар зөвлөлөөс баталсан журамд заасан шаардлагыг хангасан байна.
- Зэрэг горилогч нь мэргэжлийн болон ёс зүйн зохих шаардлагыг хангасан байна.
- Зэрэг горилогч нь зөвлөлөөс зэрэг олгох үйл ажиллагаатай холбогдуулан тогтоосон төлбөрийг төлсөн байна.

## **Гурав. Зэрэг горилох хүсэлт гаргах**

**3.1** Мэргэшлийн зэрэг горилогч нь дараах баримт, бичгүүдийг бүрдүүлж зарласан хугацаанд багтаан зөвлөлд ирүүлнэ. Үүнд:

- Зэрэг горилохыг хүссэн хувийн өргөдөл,
- Итгэмжлэгдсэн 2 хүний тодорхойлолт,
- Ажил байдлын тодорхойлолт,
- Дипломын хуулбар (баталгаажуулсан),
- Мэргэжил дээшлүүлсэн талаарх үнэмлэх, гэрчилгээ, бусад баримт бичгийн баталгаажуулсан хуулбар,
- Бүтээлийн тайлан, жагсаалт (хэвлэгдсэн ба мэдээллийн сан-фондод орсон),
- Анкет (3х4 хэмжээний 2 хувь зураг),
- Шалгаруулалтын төлбөрийн баримт.

**3.2** Горилогч нь ажил байдлын тодорхойлолтыг ажиллаж буй байгууллагаасаа авсан байна. Шаардлагатай бол холбогдох бусад байгууллага тодорхойлолт гаргаж болно.

**3.3** Бүтээлийн тайланг ажиллаж буй байгууллага болон Зөвлөх зэрэгтэй 2-оос доошгүй инженер хянаж баталгаажуулсан байна. Тайланд бүтээлийн фото зураг, нүүр хуудас, гэрчилгээний хуулбар зэргийг хавсаргана.

**3.4** Горилогч нь онцгой бүтээл гаргасан тохиолдолд горилогчийн бичгээр тавьсан хүсэлтийг үндэслэн энэ журмын 2.1–д заасан хугацааг зөвлөл хэлэлцэж багасгаж болно.

**3.5** Дараах тохиолдлуудад зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн Зөвлөл хэлэлцэж мэргэжлийн шалгалтаас чөлөөлж болно. Үүнд:

- Мэргэжлийн дагуу дагнаж 25 жилээс дээш хугацаагаар тасралтгүй үр бүтээлтэй ажилласан,
- Онцгой бүтээл гаргасан (тулгуур төсөл, хөтөлбөр, хууль эрх зүйн акт, томоохон нээлт, судалгаа удирдан боловсруулсан, хэрэгжүүлсэн г.м),
- Геологийн мэргэжлийн чиглэлээр боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан.

#### **Дөрөв. Зэрэг олгох шалгаруулалтын ажиллагаа**

**4.1** Зөвлөл нь шалгаруулалтыг горилогчийн мэдлэгийн түвшин, мэргэшлийн ур чадвар, бүтээл, туршлагыг магадлан үнэлэх замаар гүйцэтгэнэ. Инженерүүдийн мэдлэгийн түвшин болон мэргэжлийн ур чадварыг шалгалтаар, бүтээл ба туршлагыг тодорхойлолтоор, бүтээлийн тайланг зохих байгууллагаас лавлагаа авч магадлан шалгах замаар тодорхойлно.

**4.2** Шалгалт нь мэргэшсэн зэрэг горилогчид хоёр, зөвлөх зэрэг горилогчид гурав хүртэл үе шаттайгаар явагдана. Үүнд:

- *Нэгдүгээр шат.* Ерөнхий мэдлэгийн шалгалт,
- *Хоёрдугаар шат.* Мэргэжлийн шалгалт (шалгалтын агуулга нь горилж буй зэргээс хамаарч ялгаатай байна),
- *Гуравдугаар шат.* Төгсөлтийн ажлын хамгаалалт. Төгсөлтийн ажлын хамгаалалтад зураглал, эрэл хайгуул, уурхайн геологийн онцгойлох төсөл, технологийн шийдэл, судалгааны ажлын тайлан орж болно.

**4.3** Ерөнхий мэдлэгийн шалгалтыг их дээд сургуулийн сургалтын бүрэн программын хэмжээнд хураангуй байдлаар тестээр авна. Тэнцэх онооны хэмжээг комисс хэлэлцэж зөвлөлд санал оруулж тогтооно.

**4.4** Зэрэг горилогч нь мэргэжлийн шалгалтад авбал зохих нийт онооны 85 ба түүнээс дээш хувийг авбал тэнцсэнд тооцно.

**4.5** Шалгаруулалтын гуравдугаар шатанд орж буй зөвлөх зэрэг горилогч нь Зөвлөлөөс зөвшөөрсөн сэдвээр, батлагдсан зааврын дагуу төгсөлтийн ажил бичиж, зөвлөх зэрэгтэй хоёр инженер буюу эрдэмтэдээс шүүмж, санал авч мэргэжлийн шалгалтын комисст хамгаална. Энэ шатанд комисс нь горилогчийн бүтээл, туршлагыг үнэлж, нэгтгэн 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.

**4.6** Мэргэжлийн шалгалт, төгсөлтийн ажлын хамгаалалтыг зөвлөлөөс томилогдсон комисс авна. Шалгалтын комисс болон зэрэг горилогч нь батлагдсан шалгалтын журмыг баримтална.

**4.7** Шалгалтын комисс нь горилогчийн шалгалтын дүн, бүтээл, туршлагад үндэслэн зэрэг олгох саналаа зөвлөлд оруулна.

### **Тав. Зэргийг сунгах, цуцлах**

**5.1** Мэргэшсэн зэрэгтэй инженер нь гурав, зөвлөх зэрэгтэй инженер таван жил тутамд тус тус зэргээ сунгаж баталгаажуулна.

**5.2** Зэргийг 2 удаа сунгах ба хоёр дахь сунгалтаас хойш гэрчилгээнд хугацаа заахгүй. Зэргээ сунгуулах хүсэлтийг (өргөдөл) энэ хугацаанд хийсэн ажлын болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зөвлөлд бичгээр ирүүлнэ.

**5.3** Зэргээ сунгуулах тохиолдолд тайлан хамгаалалт, шалгаруулалтад 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлбэл, зэргийг сунгах саналыг зөвлөлд оруулж шийдвэрлүүлнэ.

**5.4** Дараах тохиолдлуудад зөвлөл хэлэлцэж зэргийг бууруулах, эсвэл цуцлах шийдвэр гаргаж болно. Үүнд:

- Зэргээ бууруулах эсвэл цуцлуулах хүсэлтийг мэргэжилтэн өөрөө гаргасан;
- Тайлант хугацаанд мэргэшсэн чиглэлээр ажил үйлчилгээ явуулаагүй, хангалтгүй явуулсан;

- Шалгаруулалтад хугацаандаа ороогүй;
- Шалгаруулалтад тэнцээгүй;
- Ёс зүйн ноцтой доголдол гаргасан;
- Мэргэжлийн ноцтой алдаа дутагдал гаргасан;
- Мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор гэмт хэрэгт шийтгүүлсэн.

**5.5** Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэнд зэргээ хоёр удаа амжилттай сунгуулсан тохиолдолд зөвлөх мэргэжилтний шалгаруулалтанд орох эрх нээлттэй болно.

**5.6** Зөвлөл нь горилогчын бүтээлийг холбогдох агентлаг (Ашигт малтмалын газар, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл), мэдээллийн төвөөс (Геологийн Мэдээллийн Төв, Мэдээллийн Сан) тодруулан хянан магадлах явцад бүтээлдээ худал мэдүүлэх, эсвэл бусдын бүтээлийг буруу баталгаажуулсан байдал илэрвэл буруутай этгээдэд зэрэг олгохоос түдгэлзэх, урьд авсан зэргийг нь бууруулах эсвэл хүчингүй болгоно.

### **Зургаа. Зэрэгтэй инженерийн эрх**

**6.1** Эрдсийн баялгийн үнэлгээ бүхий зураглал, эрэл хайгуулын ажлын тайланг мэргэшсэн геологич, харин ордын нөөцийн тооцоолол бүхий хайгуулын ажлын үр дүнгийн тайланг тухайн ашигт малтмалын хайгуулын чиглэлээр зөвлөх эрхтэй геологич толгойлон боловсруулна. Харин нөөцийн тооцоолол бүхий хайгуулын ажлын үр дүнгийн дээрх тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс итгэмжлэгдсэн бөгөөд монгол улсын зөвлөх геологич хянаж шалгана.

**6.2** Зөвлөх зэрэгтэй инженер нь зөвхөн өөрөө гүйцэтгэсэн, оролцсон эсвэл удирдсан, хянаж зөвлөсөн ажлын гүйцэтгэлийн тайлан, дүгнэлт, акт, баримт бичиг, зураг төсөл зэрэгт гарын үсэг зурж хувийн тэмдэгээ дарна.

**6.3** Зэрэгтэй инженер нь мэргэжлээрээ ажиллах нөхцөлд Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 51 дүгээр зүйлд заасны дагуу Зөвлөх – 20 %, Мэргэшсэн – 15 % хүртэл зэргийн нэмэгдэл авч болно.

**6.4** Зэрэг олгох болон зэргээ сунгуулах шалгаруулалтад хүндэтгэх шалтгааны улмаас орж чадаагүй бол уг шалтгааныг нотолсон баримт бичгийг тодорхой хугацаанд бүрдүүлж Зөвлөлд өгч шийдвэрлүүлнэ.

**6.5** Шалгуулагч нь шалгаруулалтын талаархи гомдол, саналаа зөвлөлд бичгээр тавьж шийдвэрлүүлнэ.

**6.6** Шалгуулагч нь шалгалтад тэнцээгүй бол нэг жилээс доошгүй хугацааны дараа шалгалтыг дахин өгөх хүсэлтийг зөвлөлд бичгээр тавьж шийдвэрлүүлнэ.

### **Долоо. Зэрэгтэй инженерийн үүрэг, хариуцлага**

**7.1** Зэрэгтэй инженер нь зөвлөлөөс баталсан загвар бүхий гэрчилгээ, хувийн тэмдэгтэй байна. Гэрчилгээ, тэмдэг дээр эзэмшигчийн овог нэр, бүртгэлийн дугаар, зэргийн хүчинтэй байх хугацааг заана. Гэрчилгээнд тухайн зэрэгтэй инженерийн ажил үйлчилгээний чиглэлийг зааж өгнө. Тэмдгийн эх загварын дардсын нэг хувийг зөвлөл болон хяналтын байгууллагад хадгалуулсан байна.

**7.2** Зэрэгтэй инженер нь ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, норм стандарт, журам зааврын дагуу техник технологийн зохих түвшинд хариуцлагатай, чанартай гүйцэтгэнэ.

**7.3** Геологийн салбарын зэрэгтэй инженер нь өөрийн бие дааж болон удирдан хийлгэсэн зөвлөмж, хянаж баталгаажуулсан ажлын үр дүн, түүний чанарыг бүрэн хариуцах ба хийсэн ажил үйлчилгээний дүгнэлтэд зөвлөх зэрэгтэй инженер тэмдэг дарж баталгаажуулна.

**7.4** Өөрийн буруугаас учирсан хохирол, хариуцлагыг холбогдох хуулийн дагуу хүлээнэ.

**7.5** Зэргээ цуцлуулсан инженер зөвлөлд хувийн тэмдэг, гэрчилгээгээ хураалгана.